



УВС АЙМАГ
ДАВСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 4/06

Зүүнхөвөө

Сумын тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасныг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Тэргүүлэх чиглэлд тусгагдсан зорилтуудыг ханган ажиллахын тулд үйл ажиллагааны хөтөлбөр, стратеги төлөвлөгөө, тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтонд тусган хэрэгжүүлж, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг дарга /Ч.Тогтохбаяр/-д үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015.12.20-ны 10/09 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.АМАРТҮВШИН